



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/162

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шивээт 4 дүгээр багийн иргэн Р.Лхагвасүрэнгийн үхрээс 2 удаагийн сүүний дээж, 1 удаагийн ийлдсийн дээж авч шинжилгээ хийхэд бруцеллёз өвчний үүсгэгч илрээгүй тул мал эмнэлгийн улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 40-02-256/02 тоотыг үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/80 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм цуцлагдсан өрхийн малд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ

622301325

D:Alban bichig,Zahiramj 2023